

"ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ" ОНӨААТҮГ-ЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Шийд- вэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	
1	2	3	
1	1.6	"Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах нийтлэг журмыг батлах тухай" 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр №311 1.6. Аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.	Байгууллагын 2020 оны эхний хагас жилийн хэрэгжүүлсэн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийсэн бөгөөд дэлхийн улс, орнуудад тархсан шинэ төрлийн коронавирус /Ковид-19/-ийн өвчлөл манай улсад илэрч, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг дарга, Нийслэл, дүүргийн онцгой комисс, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийтийн тээврийн үйлчилгээний газраас ирүүлсэн албан бичиг, захирамж, зөвлөмж, удирдамж, албан даалгаврын тодорхой заалтуудыг хяналтад авч хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Тайлант хугацааны онцлогоос шалтгаалан зарим ажлын үр дүнг тооцох хугацаа болоогүй, ажлын явцаас хэрэгжилтийг тооцох шаардлага гарсан. 2020 оны эхний хагас жилийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг бүрэн хангалттай гэж дүгнэсэн. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Дотоод хяналт шалгалтын хэлтсээс бааз, хэлтэс, албадын үйл ажиллагаанд 2020 онд хийгдэх дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг "Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналт", "Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд тавих хяналт", "Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал", "Бусад ажлын хүрээнд" гэсэн 4 чиглэлээр 27 заалттайгаар боловсруулан батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.

2	1.3	"Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдөр №258 1.3. Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Байгууллагын соёл, дэг журмыг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх" ажлыг зохион байгуулах тухай захирлын баталсан Дотоод хяналт шалгалт хэлтэс-20/02 тоот удирдамжийг батлуулан 3 заалт бүхий хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар ажлын байрны шинжилгээ хийж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоо, байгууллагын ойр орчим болон гадна талбай, угаалгын газар, граж, ажилтнуудын нийт өрөө, тасалгаанд үзлэг шалгалт хийсэн. Шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй болно.
	1.4	1.4. Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	Тус байгууллага нь ажлын байрны сул орон тоо гарсан тохиолдолд албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварыг харгалзан үзэн нөхөн бүрдүүлэлт хийдэг. Замын хөдөлгөөний дүрэм, стандартын чиглэлээр Сонгон шалгаруулах комисс шалгалт авч, шалгалтад тэнцсэн хүмүүсийг ажилд авч, хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн "Зорчигч тээврийн нэгтгэл"-ийн цахим хуудас, megui.mn, Шуурхай зар сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр нийт ажлын байрны зарыг байршуулан иргэдэд нээлттэй мэдээлэн ажиллаж байна. 2020 оны хагас жилийн байдлаар шалгалтад тэнцсэн, ажлын байрны тодорхойлолтын шаардлага хангасан, нийт 51 хүнийг мэргэжлийн дагуу сонгон шалгаруулж ажилд авсан. Үүнд: - Захиргаа-14, Нийтийн тээврийн автобусны жолооч -14, Засварчин-10, Бусад-13

3	1	"Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний" тухай 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр №106 1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд явуулсан Улсын үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, Архивын Ерөнхий газраас гаргасан заавар, дүрэм журам, эрх зүйн баримт бичгийг мөрдөн, баримт бичгийн эргэлтийн мэдээг график хэлбэрээр гаргаж хэвшсэн. Тогтоолын хүрээнд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу үйл ажиллагааны явцад үүссэн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийж данс, бүртгэлийг байгууллагын архивын жагсаалт үйлдэн хугацаанд нь батлуулсан. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулан хэлтэс, баазуудаас нийт 1057 хадгаламжийн нэгж хүлээн авч, архивын жагсаалт үйлдэн ажилласан. Үүнээс: Байнга хадгалах хадгаламжийн нэгж-316 70 жил хадгалах хадгаламжийн нэгж-39 Түр хадгалах хадгаламжийн нэгж-702 хадгаламжийн нэгж байна. Мөн цахим Archive eDoc-т байнга хадгалах цаасан суурьт баримт 563, 70-жил хадгалах цаасан суурьт баримт 6081 байна. Нийт 6644 тушаалуудыг шивж оруулсан.
4	1	"Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр №62 1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс мөн оны 3 дугаар сарын 2-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсүгэй.	Нийслэлийн "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын 1 дүгээр баазын гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд захирлын 2020 оны 3-дугаар сарын 23-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Орон тооны бус штаб, мэргэжлийн анги томилох тухай, мөн 2020 оны 4-дүгээр сарын 1-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг байгуулах, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг удирдах бүрэлдэхүүнийг албан тушаалтнуудыг шинэчлэн баталж Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсээр батлуулсан. Цаг агаарын хүйтрэлттэй холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, сахилга хариуцлага эмх цэгцийг өндөржүүлэхэд хяналт тавих хариуцлагатай эргүүл хийх хуваарийн дагуу байгууллагын албан хаагчид 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал өндөржүүлсэн байдалд ажиллан эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэсэн ба 2 удаагийн эргүүл жижүүр хийсэн байдалд үнэлэлт дүгнэлт хийн ажиллалаа.
5	11	"Шинэ Коронавирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр №30 11. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх,	Нэгтгэл болон 1, 2 дугаар баазуудын хэмжээнд эмч нар 7 хоногт 2 удаа буюу нийт 20 удаа жолооч, шалгагч нарт дархлаа дэмжих зорилгоор өглөө халуун аарц, чацаргана өгч мөн нийт 20 удаагийн давтамжтайгаар 10000 ширхэг маск, 10000 ширхэг витамин-С тарааж, гар ариутгагчийг нийт тээврийн хэрэгсэлд байршуулж, ажилтан алба хаагч нарын хувийн ариун цэврийг сайтар сахиулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх

		ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт уриалсугай.	холбогдох дээд шатны байгууллагуудаас гаргасан 6-н төрлийн 750 ширхэг санамж, зөвлөмжийг хэвлүүлэн нийт 287 автобусанд болон мэдээллийн самбарт байршуулж иргэд болон албан хаагчдыг мэдээллээр бүрэн хангаж ажиллаж байна.
6	2.1	"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай" 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр №33 2.1 Төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө.	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн "Ёс зүйн дүрэм"-ийг баталсантай холбогдуулан нийт 1208 ажилтан, албан хаагчдад "Ёс зүйн дүрэм"-ийг танилцуулан, дагаж мөрдөж байна. Байгууллагын захирлын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/21 тоот тушаалаар "Ёс зүйн зөвлөл"-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Зөвлөл байгуулагдсанаас хойш 1 гомдлыг хянан хэлэлцсэн бөгөөд Ёс зүйн дүрмийн дагуу уучлал гуйх арга хэмжээг тооцон ажилласан болно.

7	1	"Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдөр №102 1. (Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа Covid-19) -ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгасугай.	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан 05 дугаар сарын 07-ны өдөр 08:00-18:00 цаг хүртэл Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах дадлага сургуулилтын арга хэмжээний үеэр тус нэгтгэлийн 4:8, 4:23 чиглэлүүдийн нийт 17 гаралтын шугамын үйлчилгээний өглөөний эх авалтыг бүрэн авахуулж, тогтоосон хугацаанд бүрэн зогсоож, 4:9, 4:43, 4:63 чиглэлүүд нийт 25 гаралт богино эргэлт хийж, 4:57, 4:66, 4:70 чиглэлүүдийн нийт 22 гаралт уртасгасан замналаар явж, гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн үеэр тээврийн хэрэгсэл, жолооч нарын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангаж, шугамын үйлчилгээний шуурхай зохицуулалтыг хийж, мөн 1, 2 дугаар баазуудын "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-ний дагуу томилогдсон "Аврах бүлэг"-т зарлан мэдээлэл хүргүүлж 1 дүгээр бааз 9 хүний бүрэлдэхүүнтэй, 2 дугаар бааз 14 хүний бүрэлдэхүүнтэй бэлэн байдалтай ажилласан. Ус цаг уур орчны шинжилгээний төвийн мэдээллийн дагуу цаг агаарын аюултай үзэгдэл болох магадлалтай гэснээр 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/204 тоот албан бичгийн хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд 1, 2 дугаар баазуудын "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-ний дагуу томилогдсон "Аврах бүлэг"-т зарлан мэдээлэл хүргүүлж бэлэн байдалтай ажиллалаа. Байгууллагын хэмжээнд шугамын үйлчилгээний нийт 287 тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг 1 дүгээр бааз 95%, 2 дугаар бааз 92%-тай хангаж бэлтгэл тээврийн хэрэгсэл, жолооч нарыг нөөцөд бэлтгэж ажилласан.
	4	4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай.	Шинэ коронавирус /Covid-19/ цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор ариутгал халдваргүйжүүлэлтийн мэргэжлийн байгууллага "ДДД андууд нөхөрлөл" ХХК, "Шинэ ариусал" ХХК-тай хамтарч байгууллагын 11 объект нийт 7652 м2 талбайд 9 удаа 4121860 /дөрвөн сая нэг зуун хорин нэгэн мянга найман зуун жаран төгрөг/-ний ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж ажилласан. Нийтийн Тээврийн Үйлчилгээний газартай байгуулсан гэрээний үүргийн дагуу үндсэн нийт 23 чиглэлд ажлын өдөр 180 гаралт, амралтын өдөр 148 гаралт гаргаж, өдөр бүр 1 автобус, 6-8 шалгагч хувиарлан эцсийн буудлууд дээр тээврийн хэрэгслийн дотор чийгтэй цэвэрлэгээ тогтмол хийлгэж байна. Тайлант хугацаанд тус нэгтгэл нь өглөөний гаралт оройн буултаар нийт 287 тээврийн хэрэгслийн гадна, дотор заал, зорчигчдын бариул, цонх, гадаргууг угааж, ариутгал халдваргүйжүүлэлтийг 121 шалгагч нарыг хувиарлан ажиллуулж 02, 03, 04 дүгээр саруудад ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис 6.851 кг жавелин, 19.110 кг угаалгын нунтаг, 24.810 литр спиртийг тараан өгч ариутгал цэвэрлэгээг хийсэн.

8	4	2020 оныг "Нэг хот-Нэг стандарт болгон зарлах тухай 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр №1	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын өдөр №1 захирамжийн хүрээнд нийслэл хотоос баримталж буй бодлогыг иргэд, олон нийтэд сурталчилж, иргэд олон нийтэд сурталчилж, иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх үйл хэргийг бүх нийтийн хэрэг болгох зорилгоор зохион байгуулж буй "Хотын соёл" аяныг өрнүүлэн, Хамтдаа өөрчилье уриан дор 8 зорилт, 20 заалт бүхий хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөө гарган байгууллагын захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийтийн Тээврийн Үйлчилгээний Газартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 19-ний өдөр хүртэл үндсэн нийт 23 чиглэлд ажлын өдөр 201 гаралт, амралтын өдөр 154 гаралт гаргаж нийт 508
8	4	4.Зорилтод жилийн хүрээнд нийслэлээс зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллага, нэгж бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, үйл ажиллагаандаа уялдуулан ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.	мэргэшсэн жолоочоор нийслэлийн иргэд хөдөлмөрчдөд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг чанарын стандартыг чанд мөрдөн үйлчилгээг хүргэн ажилласан. Үйлчилгээний даалгаврыг хэрэгжүүлэн өглөөний эх авалт 99.2%, оройн гаралт 98.6%-тай, цагийн түвшин 98.8% гүйцэтгэж, нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлээр зам тээврийн осол зөрчилгүй, гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангаж ажилласан. 2020 оны 06 дугаар 02-ны өдөр "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS:5012-2011 стандартын хэрэгжилтийг хангах, үйлчилгээний чанар хүртээмж, сахилга хариуцлага, хөдөлгөөний соёл, дэг журмыг сайжруулах, осол зөрчил санал гомдлыг бууруулан 14 чиглэлээр удирдамж гарган батлуулж, үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.
9	1	"Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр №168 1. Шинэ коронавирусын халдвар болон Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг бусад халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс гудамж, зам талбай, нийтийн эзэмшлийн болон үйлчилгээний газар, орон сууцны орчны газарт нус цэр шүлсээ хаяхгүй байх, ил задгай бие засах болон хог хаягдлаар орчноо бохирдуулахгүй байх үүргээ биелүүлэхийг Нийслэлийн хотын иргэн бүрд уриалсугай.	Шинэ коронавирусын халдвар болон бусад халдварт өвчний эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс гудамж, зам талбай, нийтийн эзэмшлийн болон үйлчилгээний газар, орон сууцны орчны газарт нус цэр шүлсээ хаяхгүй байх, ил задгай бие засах болон хог хаягдлаар орчноо бохирдуулахгүй байх 5-н цуврал мэдээ бэлтгэн www.bus.gov.mn сайт, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын цахим хуудсанд байршуулан 1208 ажилтан хаагч болон олон нийтэд хүргэсэн. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах, иргэдийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 1000 ширхэг зөвлөмжийг иргэдэд тараасан. 284 автобусанд зорчигчдод зориулсан ил задгай хог хаяхгүй байх, нус, цэр шүлсээ ил задгай хаяхгүй байх, амны хаалтаа зүүж хэвших зэрэг 8 анхааруулга, зөвлөмж бүхий санамжийг наасан. 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны Засаг даргатай гурвалсан 20/03-18 тоот "Тохижилт, цэвэрлэгээний гэрээ" байгуулж, гэрээний дагуу байгууллагын болон орчны 50 метр газрын цэвэрлэгээ үйлчилгээг сар бүрийн 15, 30-ны өдрүүдэд тогтмол хийж ажиллаж байгаа бөгөөд 2020 оны эхний 5 сарын байдлаар байгууллагын хэмжээнд хуримтлагдсан хогийг гэрээт компаниар 43 удаа ачуулсан.

10	2.2	"Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр №191 2.2 Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэн, хариуцлагатай эргүүл жижүүр томилон ажиллуулахыг дүүргийн Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагын болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын дарга, удирдах албан тушаалтанд даалгасугай.	Сүхбаатар дүүргийн Онцгой комиссын даргын баталсан Эргүүлээр ажиллах албан хаагчдын удирдамж, хуваарийн дагуу хариуцсан бүс буюу Сүхбаатар дүүргийн 8, 14, 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрүүдэд хариуцлагатай эргүүлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Нэгтгэлийн 121 ажилтан албан хаагч 31 удаа - Нэгдүгээр баазын 196 ажилтан албан хаагч 37 удаа - Хоёрдугаар баазын 196 ажилтан албан хаагч 37 удаа давхардсан тоогоор нийт 513 ажилтан албан хаагчид, 105 удаагийн эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэсэн. Удирдамжийн дагуу албан хаагчид хувийн бэлтгэл ханган амны хаалтыг тогтмол хэрэглэж, хуваарьтай хороодын Засаг даргын ажлын албанд 15-20 минутын өмнө очиж, Хорооны Засаг даргаас хуваарилсан маршрутын дагуу хорооны дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн татварын хэлтэс, Соёлын төв өргөө, Статистикийн хэлтэс, боловсролын хэлтэс, Сүхбаатар дэвшил, ЖДҮДТ-ийн ажилтнуудтай эргүүл хийж, иргэд, хуулийн этгээдүүдэд коронавирусын халдвараас сэргийлэх талаар зөвлөмж, зөвлөгөө өгч, амны хаалт хэрэглээгүй иргэд, байгууллагын ажилтнуудад шаардлага тавьж зөрчлийг арилгуулан, эргүүлээр ажилласан тухай мэдээг мэдээний хүснэгтийн дагуу 23:00 цагт хорооны Засаг даргын Ажлын албанд өгч ажилласан. Байгууллагын 2020 оны 06 дугаар сарын 4-ний өдрийн 1/529 тоот албан бичгээр тайланг Нийлэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан.
----	-----	--	--

11	1	"0-12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр №268 1. Амьсгалын замын цочмог халдвар, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжиж, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан Нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллага, Орон нутгийн Өмчит үйлдвэрийн газрын 12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн /ганц бие эцэг/ ажлын цагийг 1 цагаар хорогдуулж ажиллуулахыг байгууллагын удирдлагуудад зөвшөөрсүгэй.	Шинэ коронавирус /Covid-19/ халдвар тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор жирэмсэн болон 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн /ганц бие эцэг/ цагийг хорогдуулсантай цагаар ажиллахтай холбогдуулан Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын Захирлын 2020 оны 3 дугаар сарын 13-ны А/16 дугаар тушаалаар 2020 оны 4 дүгээр сарын 30-н хүртэл жирэмсэн 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийг /ганц бие эцэг/цахим байдлаар ажлаа хийх нөхцөл боломжоор хангагдаж, ажлын цагийг 1 цагаар хорогдуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдуулахгүйгээр ажилласан.
----	---	--	--

12	1	"Шагнаж урамшуулах тухай" 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр №747 Дэлхий нийтэд тархаад байгаа Коронавируст (КОВИД-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах ажилд идэвх санаачилгатай ажилласан, Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу Коронавируст (КОВИД-19) цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ сэдэвт гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулийг үр дүнтэй сайн зохион байгуулсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтныг шагнаж урамшуулсугай.	Тус захирамжийн хүрээнд Дэлхий нийтэд тархаад байгаа Коронавируст (КОВИД-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдварт өвчинтэй тэмцэх, ариутгал цэвэрлэгээг тогтмол хийх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлах үйл ажиллагаанд идэвх санаачилгатай ажилласан ажилтан албан хаагчдыг Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын Захирлын 2020 оны дүгээр сарын 01-ний өдрийн А/30 дугаар тушаалаар Хоёрдугаар баазыг, 2020 оны 05 дугаар сарын 18-ны А/39 дүгээр тушаалаар Нэгдүгээр баазыг тус бүр 500000 төгрөгөөр шагнаж урамшуулсан.
13	9	2020 оны 09 дүгээр хуралдаан 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2020 оны 09 дүгээр хуралдаанаас иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх, шийдвэрлээгүй ажилтанд хариуцлага тооцох, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, иргэдээс гаргасан саналын шинжтэй өргөдлийг байгууллагын үйл ажиллагаанд тусгаж, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлан мэдээнд тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулж хэвших	